


### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

**Санамж:** Нэгдүгээр хэсэг нийт 50 даалгавартай бөгөөд 1-25 дугаар даалгавар тус бүр 1 оноо, 26-41 дүгээр даалгавар тус бүр 2 оноо, 42-50 дугаар даалгавар тус бүр 3 оноотой. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой.

- Кофены ургамлыг хамгийн бага тариалдаг улс аль нь вэ?  
 A. Бразил  
 B. Замби  
 C. Уганда  
 D. Колумб  
 E. Этиоп
- Таримал ургамал үүссэн төвүүдийг харуулсан зурагт Өмнөд Америкийг хэдийн тоогоор тэмдэглэсэн бэ?



- 8
- 7
- 6
- 4
- 5

- Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Геологийн бүтцээр хуурай газартай адилхан эх газрын усан доорх үргэлжлэл болох далайн ёроолын хэсгийг . . . . . гэнэ.  
 A. арал  
 B. эх газрын тан  
 C. булан  
 D. хойг  
 E. садраа эрэг
- Монгол улсын эдийн засгийн Зүүн бүсэд хамрагдах аймгууд аль нь вэ?  
 A. Баян-Өлгий, Ховд, Увс  
 B. Баян-Өлгий, Увс, Завхан  
 C. Хэнтий, Дорнод, Сүхбаатар  
 D. Хэнтий, Дорноговь, Сүхбаатар  
 E. Дорнод, Дорноговь, Сүхбаатар
- Австрали ба далайн орнуудад хамаарах хаант засаглалтай улс аль нь вэ?  
 A. Тонга  
 B. Сингапур  
 C. Их Британи  
 D. Куба  
 E. Ямайка
- Тэнгисийн эргийн аялал, амралтаар хамгийн их жуулчин очдог газар нутаг аль нь вэ?  
 A. Улаан тэнгис  
 B. Газар дундын тэнгис  
 C. Агнуурын тэнгис  
 D. Арафурын тэнгис  
 E. Тасманы тэнгис
- Далайд гарцгүй Африк тивийн улс аль нь вэ?  
 A. Мавритан  
 B. Марокко  
 C. Алжир  
 D. Ангол  
 E. Чад

8. Цэгийн оронд байх зөв утгыг сонгоно уу. Соронзон зүү босоо орших дэлхийн гадарга дээр цэгийг ..... гэнэ.
- A. соронзон шуурга  
B. соронзон туйл  
C. соронзон гаж  
D. соронзон гүр  
E. соронзон азимут
9. Байгалийн бүсийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах, унаган төрхөө хадгалсан, шинжлэх ухаан хүн төрлөхтний соёл иргэншлийн онцгой ач холбогдолтой газар нутгийг юу гэж нэрлэдэг вэ?
- A. Дурсгалт газар  
B. Байгалийн цогцолборт газар  
C. Дархан цаазат газар  
D. Байгалийн нөөц газар  
E. Шим мандлын нөөц газар
10. Халх гол хаанаас эх авдаг вэ?
- A. Хянганы уулсаас  
B. Хангайн нуруунаас  
C. Хэнтийн нурууны баруун өмнө хажуугаас  
D. Монгол Алтайн Таван богд уулнаас  
E. Хэнтийн нурууны зүүн хойд хажуугаас
11. Цэгийн оронд тохирох үгийг олно уу. .... тоо толгойгоор ..... улс дэлхийд хоёрдугаарт ордог бөгөөд ..... экспортоор дэлхийд тэргүүлдэг. Энэ улс нь дангаар нэг эх газрыг эзлэн оршдог.
- A. Адууны, Хятад, хонины ноосны  
B. Хонины, Австрали, хонины ноосны  
C. Хонины, Австрали, үхрийн махны  
D. Ямааны, Австрали, хонины ноосны  
E. Гахайн, Хятад, гахайн махны
12. Номхон далайн ай савд хамаарах гол аль нь вэ?
- A. Сэлэнгэ, Туул  
B. Онон, Онги  
C. Онон, Улз  
D. Завхан, Таац  
E. Улз, Байдраг
13. Монгол улсын хойд захын цэгийн солбицол аль нь вэ?
- A. х.ө  $46^{\circ} 52'$  з.у  $103^{\circ} 50'$   
B. х.ө  $48^{\circ} 53'$  з.у  $87^{\circ} 44'$   
C. х.ө  $46^{\circ} 43'$  з.у  $119^{\circ} 56'$   
D. х.ө  $52^{\circ} 09'$  з.у  $98^{\circ} 57'$   
E. х.ө  $41^{\circ} 35'$  з.у  $105^{\circ} 00'$
14. Монгол орны хамгийн өндөрт орших аймгийн төв аль нь вэ?
- A. Баянхонгор  
B. Чойбалсан  
C. Мөрөн  
D. Арвайхээр  
E. Алтай
15. Дараах нууруудаас аль нь тектоникийн гаралтай вэ?
- A. Толбо, Даян  
B. Буйр, Гангын цагаан  
C. Хөвсгөл, Тэрхийн цагаан  
D. Тэрхийн цагаан, Хагийн хар  
E. Буйр, Хяргас
16. С.Н.Потанин Монгол Алтай, Их нууруудын хотгор, Говь, Хянганы уулсаар аялж судалж ном бичжээ. Энэ номын нэрийг олно уу.
- A. Баруун Монгол ба Урианхайн хязгаар  
B. Орчлонгийн элдэв сонин  
C. Баруун хойд Монголын тодорхойлолт  
D. Монгол ба Тангадын орон  
E. Монгол ба Кам

17. Манай улсын аль аймаг БНХАУ-ын Өвөр Монголын ӨЗО-той хиллэдэг вэ?

- A. Баян-Өлгий  
B. Завхан  
C. Сүхбаатар  
D. Сэлэнгэ  
E. Булган

18. Ази тивийн хөгжингүй улс аль нь вэ?

- A. Монгол  
B. Өмнөд Солонгос  
C. Бутан  
D. Малайз  
E. Вьетнам

19. Дараах бүдүүвчид байгаа асуултын тэмдгийн оронд тохирох үгийг олно уу?



- A. үхэр тэрэг  
B. тэмээн жин  
C. такси  
D. автобус  
E. дамжуулах хоолой

20. Биологийн олон янз байдлын тухай конвенцид манай улс 1993 онд нэгдсэн орсон. Амьтдыг нэн ховор, ховор, элбэг гэж гурав ангилна. Доор дурьдсан амьтдаас нэн ховор амьтад аль нь вэ?

- A. Галуу, чоно, бүргэд, минж, нугас  
B. Цагаан зээр, ирвэс, минж, халиу, чоно  
C. Тарвага, шивэр хандгай, буга, баавгай, хэрээ  
D. Реликт цахлай, цэн тогоруу, монгол бөхөн, халиу  
E. Тас, элээ, минж, ирвэс, булга

21. Уулын чулуулаг карбонатжих нь аль өгөршлийн төрөлд хамаарах вэ?

- A. Органик өгөршилд  
B. Физик өгөршилд  
C. Температурын өгөршилд  
D. Химийн өгөршилд  
E. Салхины өгөршилд

22. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Мөнх хүйтний бүслүүр нь хамгийн дулаан сарын .....<sup>0</sup>C-ийн изотерм болон хойд, өмнөд туйлын хооронд оршино.

- A. +20    B. 0    C. +10    D. -5    E. -10

23. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Усны хүчиллэг байдал нэмэгдэх нь усны амьтад хөнөөл учруулна. Өвлийн турш хуримтлагдсан хүчиллэг цас хавар хайлах үед усны pH огцом өөрчлөгддөг бөгөөд хор хөнөөл нь улам нэмэгддэг. Үүнийг “.....” гэж нэрлэжээ.

- A. хүчиллэг бороо  
B. шүлтлэг бороо  
C. усны дулаан  
D. шүлтийн шок  
E. хүчлийн шок

24. Дараах хариултуудаас 1:25 000 масштабтай зургийн хуудасны нэрлэлийг сонгоно уу.

- A. L-48-A    D. L-48-96-A  
B. L-48    E. L-48-96-A-a  
C. L-48-123


25. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Геометрийн дүрс, тухайн зүйлийг төлөөлсөн зураг, үсэг, тоо зэргийг ашиглан тодорхой цэгт байрласан, эсвэл талбайгаар маш бага юмс, үзэгдлийг илэрхийлэх аргыг ..... гэнэ.

- A. цэгийн арга
- B. талбайн арга
- C. ижил шугамын арга
- D. тэмдэгтийн арга
- E. хөдөлгөөнт шугамын арга

26. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг хэрхэн тооцоолдог вэ?


- A. Нийт хүн амаас нийт ажиллагсдын тоог хасна
- B. Нийт хүн амаас нийт ажиллагсдын тоог хасаж, 100%-иар үржүүлнэ
- C. Ажиллагсдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж, 100%-иар үржүүлнэ
- D. Хувиараа хөдөлмөр эрхлэгч бүх хүний тоон дээр аж ахуйн нэгж байгууллагад харьяалалтай нийт хүнийг нэмнэ
- E. Хувиараа хөдөлмөр эрхлэгч бүх хүний тоон дээр аж ахуйн нэгж байгууллагад харьяалалтай нийт хүнийг нэмэж 100%-иар үржүүлнэ

27. Дараах бүвүүвчийн хоосон нүдэнд тохирох үгийг сонгоно уу.



- A. чулуун мандлын
- B. шим мандлын
- C. хүнс тэжээлийн
- D. уур амьсгалын
- E. усны нөөцийн

28. Хөрсний зүсэлтийн зурагт C үсгээр юуг тэмдэглэсэн бэ?



- A. Гадарга
- B. Дээд хөрс
- C. Доод хөрс
- D. Эх чулуулаг
- E. Угаагдлын үе

29. Хөвсгөл аймаг дахь аялал жуулчлалын үзмэрүүд аль нь вэ?


- A. Хар хорин, Тэрхийн цагаан нуур, Рашаан хад, Отгонтэнгэр уул, Хүйсийн найман нуур
- B. Хөвсгөл нуур, Даян дээрхийн агуй, Буган цаа, Уушгийн өврийн дөрвөлжин булш, Толжийн боомын хадны зураг
- C. Уран уул, Түвхэн хийд, Эрдэнэ зуу, Хүйсийн найман нуур, Улаанцутгалан
- D. Хөвсгөл нуур, Хоргын тогоо, Тэрхий цагаан нуур, Булган уул, Чулуут голын хадны зураг
- E. Орхоны хөндий, Хөвсгөл нуур, Хар зүрхний хөх нуур, Балдан бэрээвэн хийд,

30. Зурагт үзүүлсэн рельефийн хэлбэр геоморфологийн ямар үйл явцын үр дүнд үүссэн бэ?



- A. Салхины үйл ажиллагаагаар
- B. Урсгал усны үйл ажиллагаагаар
- C. Дефляцийн үйл ажиллагаагаар
- D. Мөсөн голын үйл ажиллагаагаар
- E. Галт уулын үйл ажиллагаагаар

31. Хүн амын нас хүйсийн суваргын 10- 14 насны хүн амын тоо бага байхад нөлөөлсөн гол хүчин зүйл аль нь вэ?




- A. Дайн
- B. Ган
- C. Зуд
- D. Зах зээлийн эдийн засагт шилжсэн
- E. Газар хувьчилсан

32. Үхрийн аж ахуй эрхлэхэд тохиромжтой мал аж ахуйн муж аль нь вэ?

- A. Их нууруудын хотгор
- B. Нууруудын хөндий
- C. Төв ба Дорнодын тал хээрийн муж
- D. Өмнөговийн муж
- E. Говь гурван сайхан

33. Б.П.Алисовын ангилалаар хийгдсэн Евразийн уур амьсгалын бүсийн зурагт 4-ийн тоогоор ямар бүсийг тэмдэглэсэн вэ?



- A. Тропикийн
- B. Экватор орчмын
- C. Сэрүүн
- D. Туйл орчмын
- E. Туйлын

34. Арлуудыг орших далайтай нь зөв тохируулна уу.

- |                      |                      |
|----------------------|----------------------|
| 1) Алеутын арлууд    | a) Атлантын далай    |
| 2) Ариун Елений арал | b) Умард мөсөн далай |
| 3) Амирантын арлууд  | c) Энэтхэгийн далай  |
| 4) Хойд газрын арал  | d) Номхон далай      |
- A. 1a, 2c, 3d, 4b
  - B. 1b, 2c, 3d, 4a
  - C. 1d, 2a, 3c, 4b
  - D. 1c, 2a, 3d, 4b
  - E. 1d, 2b, 3a, 4c

35. 3 цагийн хугацаанд дэлхий тэнхлэгээ хэдэн градусаар эргэх вэ?

- A.  $60^{\circ}$
- B.  $15^{\circ}$
- C.  $30^{\circ}$
- D.  $75^{\circ}$
- E.  $45^{\circ}$

36. Дэлхийд төмөрлөгийн 10 том корпорацийн 6 нь, автомашины 10 том компанийн 5 нь, дэлхийн хамгийн том атомын цахилгаан станц Фүкусима энэ улсад байдаг. Цахилгаан техникийн Сони, Шарп зэрэг том компаниуд нь үндэстэн дамнасан корпораци болсон ба салбарууд нь Сингапур, Хятад зэрэг олон оронд бий. Энэ аль улс вэ?

- |           |         |
|-----------|---------|
| A. Герман | D. Япон |
| B. Швед   | E. ОХУ  |
| C. Канад  |         |

37. 2005 онд 14 аймгийн 63 сум, нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт 180 удаа удаа түймэр гарсны улмаас ойн 431761 га талбай, хээрийн 4785195 га талбай шатсан. Нийт хэдэн км<sup>2</sup> газар түймэрт өртсөн бэ?

- A. 52169.56 км<sup>2</sup>
- B. 5216956 км<sup>2</sup>
- C. 5216,956 га
- D. 5196956 км<sup>2</sup>
- E. 5196956 га

38. Дэлхийн 75 оронд газрын тос олборлодог бөгөөд нийт олборлолтын 90% нь тэргүүлэгч 10 оронд л ногдоно. Газрын тос экспортлогч орнуудыг холбоо гэж байдаг ба энэ холбоонд багтдаггүй орныг олно уу.

- |                |           |
|----------------|-----------|
| A. Саудын Араб | D. Ирак   |
| B. Алжир       | E. Монгол |
| C. Иран        |           |

39. Байгалийн унаган төрхийг хамгаалах төрөл бүрийн арга зам байдаг. Манай улсын тусгай хамгаалалттай 61 газар байдаг. Эдгээрээс доор өгөгдсөн газруудыг орших аймагтай нь харгалзуулснаас зөвийг нь сонгоно уу.

- |                    |            |
|--------------------|------------|
| 1) Булган гол      | a) Увс     |
| 2) Хан Хөхий       | b) Ховд    |
| 3) Хорьдол Сарьдаг | c) Дорнод  |
| 4) Нөмрөг          | d) Хөвсгөл |
- A. 1a, 2b, 3c, 4d  
 B. 1b, 2d, 3c, 4a  
 C. 1b, 2a, 3d, 4c  
 D. 1a, 2c, 3d, 4b  
 E. 1b, 2c, 3d, 4a

40. Хүснэгтэнд өгөгдсөн мэдээллийн зөв тохируулна уу.

Тэнгисийн нэр	дугаар	Далайн нэр	Тэмдэглэгээ
Япон	1	Номхон	a
Арабын	2	Умард мөсөн	b
Карибын	3	Атлантын	c
Карын	4	Энэтхэгийн	d

- A. 1c, 2a, 3d, 4b  
 B. 1d, 2b, 3a, 4c  
 C. 1a, 2d, 3c, 4b  
 D. 1d, 2c, 3a, 4b  
 E. 1b, 2d, 3c, 4a


41. Хүн ам нь 10 саяас дээш, газар нутгийн хэмжээ нь 1 сая км<sup>2</sup>- аас их улс орнууд аль нь вэ?

- A. Австрали, Канад, Чили, Дани, ОХУ  
 B. Португал, Индонез, Перу, Мексик, Конго  
 C. Саудын Араб, Алжир, Хойд Солонгос, Өмнөд Солонгос, ОХУ  
 D. Египт, Перу, АНУ, ОХУ, Канад  
 E. Испани, Лаос, Герман, Алжир, Вьетнам

42. Тухайн бүс нутаг нь дэлхийн улс төр, эдийн засаг, соёл, боловсролын гол төв бөгөөд 500 гаруй сая хүн амтай, 62 үндэстэн амьдарч байна. Эдийн засгийн гол салбарууд нь аж үйлдвэр, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй юм. Энэ бүсийн зарим орнууд нэгдсэн мөнгөн тэмдэгттэй бол энэ аль бүс нутаг вэ?

- A. Европ  
 B. Өмнөд Ази  
 C. Өмнөд Америк  
 D. Төв Америк  
 E. Зүүн өмнөд Ази

43. Швед улс нь модон эдлэлийн үйлдвэрлэлээрээ алдартай ба ижил өргөрөгт орших бусад улсуудаас харьцангуй дулаан, чийглэг уур амьсгалтай. Үүнд нөлөөлдөг далайн урсгал хэдийн тоогоор тэмдэглэгдсэн вэ?



- A. 6  
 B. 7  
 C. 12  
 D. 9  
 E. 4




44. Агаар бохирдуулагч элемент ба түүний эх үүсвэрийг зөв харгалзуулна уу.

- |                          |   |
|--------------------------|---|
| 1) Угаарын хий           | a) Бүрэн бус шаталт, биомассын шаталт               |
| 2) Суспензууд            | b) Түлшний шаталт, үйлдвэр                          |
| 3) Метан                 | c) Далайн давс, тоос шороо                          |
| 4) Метан бус гидрокарбон | d) Цагаан будааны тариалан, хөрсний гулсалт, амьтан |


- A. 1b, 2a, 3c, 4d  
 B. 1d, 2b, 3c, 4a  
 C. 1c, 2d, 3b, 4a  
 D. 1b, 2c, 3d, 4a  
 E. 1d, 2a, 3b, 4c

45. Дараах зурагт дүрслэгдсэн физик газарзүйн объектыг сонгоно уу.



- A. Рельеф  
 B. Барилга  
 C. Зарын самбар  
 D. Зам  
 E. Хашаа


46. Дараах зурагт анхдагч үйлдвэрлэлийн салбарт ажиллагчдын хувь хэмжээгээр хамгийн бага улс хэдийн тоогоор тэмдэглэгдсэн бэ?



- A. 1  
 B. 2  
 C. 3  
 D. 5  
 E. 6




47. Тавын тоогоор хотын ямар функцийг тэмдэглэсэн бэ?




- A. Баячуудын хороолол
- B. Захын бизнес дүүрэг
- C. Хотын захын орон сууцны дүүрэг
- D. Бөөний худалдаа, хөнгөн үйлдвэр
- E. Дундаж орлоготой иргэдийн хороолол

48. Жуулчин А цэгт Конго мөрний сав газраар аялаад, Оранж голын хойд талд Б цэгт аялалаа үргэлжүүлсэн бол байгалийн ямар бүсээс ямар бүсэд очсон бэ?




- A. Саванны бүсээс цөлийн бүс рүү
- B. Саванны бүсээс хатуу навчит ой , бутлаг ургамлын бүс рүү
- C. Экваторын чийглэг ойгоос саванны бүс рүү
- D. Экваторын чийглэг ойгоос цөлийн бүс рүү
- E. Цөлийн бүсээс экваторын чийглэг ойн бүс рүү

49. 2005 онд Хэнтий аймагт 2, Хөвсгөл аймагт 1, Архангай аймагт 1, Төв аймагт 1 удаа, нийт 5 удаа аадар бороо, үер буусны улмаас 2430 толгой мал хоргоджээ. Монгол улсын газрын зурагт эдгээр аймгуудыг хэдийн тоогоор тэмдэглэсэн вэ?



- A. 13, 3, 12, 6
- B. 11, 8, 5, 12
- C. 12, 11, 6, 15
- D. 14, 8, 11, 6
- E. 13, 14, 12, 11

50. Б цэг дээр агаарын температур  $3,5^{\circ}\text{C}$  байсан бол Д цэг дээр хэдэн хэм байхыг бодож олно уу?



- A.  $1,3^{\circ}\text{C}$
- B.  $-2,6^{\circ}\text{C}$
- C.  $-1,3^{\circ}\text{C}$
- D.  $-0,7^{\circ}\text{C}$
- E.  $-1,8^{\circ}\text{C}$

### ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТООЦООЛОХ ДААЛГАВАР

**Санамж:** Хоёрдугаар хэсэг нь тус бүр 4 оноотой 4 даалгавраас бүрдэнэ. Даалгаврын хариуг хариултын хуудсанд дараах байдлаар тэмдэглэнэ үү. *Жишээлбэл:*

- Эцсийн хариу 342 гэж гарсан бол a-3, b-4, c-2 гэж бөглөнө.
- Нарны өндөр олох бодлогын хариу  $75^{\circ}28'$  гэж гарсан гэж үзвэл a-7, b-5, c-2, d-8 гэж бөглөнө.

2.1. Улаанбаатар хот х.ө  $47^{\circ}55'$ , з.у  $107^{\circ}$  оршдог. Тэгвэл 12 дугаар сарын 22-нд үдийн нарны өндөр хэдэн градус, хэдэн минут байхыг бодож олно уу.

2.2. 1:2500000 масштабтай зураг дээр 3 см зурагдсан зай 1:50000 масштабтай зураг дээр хэдэн см зурагдах вэ?

2.3. з.у  $32^{\circ}$ - т орших нутагт өглөөний 11 цаг болж байхад Улаанбаатар хотод хэдэн цаг болж байх вэ?

2.4. Тухайн голын өргөн 15 м, голын хамгийн гүн хэсэг нь 4 м бол голын хөндлөн огтлолын талбай хэдэн  $\text{м}^2$  байх вэ?